



СӨБ БОЛОН ЕБС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД ХИЙСЭН АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭ

Д.Амартүвшин^а, О.Дэлгэрмөрөн^б

^а МУБИС-Багшийн сургууль, дэд профессор;

^б МУБИС-Багшийн сургууль, багш, магистр

Холбоо барих зохиогч: delgermurun@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.08.30

Хянагдсан: 2025.09.30

Зөвшөөрсөн: 2025.10.30

Хураангуй

Энэхүү судалгаа нь Монгол улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний А/176 тоот тушаалаар батлагдсан “СӨБ болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д агуулгын задлан шинжилгээ хийж, үзэл баримтлалын бүтэц, зорилго, зарим онцлог, агуулгыг судлах зорилготой юм. Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд агуулгын шинжилгээг T-LAB10 программаар хийсэн бөгөөд сургалтын шинэ үзэл баримтлалын бүтэц, үгийн тоо болон давтамж, кластерууд, хамгийн их давтагдсан үгийн бусад үгтэй холбогдсон байдал, сонирхож буй үгсийн холбоо хамаарал зэрэг үзүүлэлтээр хийлээ. Мөн шинэ үзэл баримтлалын онцлог, эрх зүйн орчин, өмнөх хөтөлбөрөөс ялгарах ялгаа зэргийг авч үзэн судалсан болно.

Түлхүүр үг

Үгсийн холбоо хамаарал, суралцагч, мэдлэг, чадвар, хандлага, кластер шинжилгээ

Удиртгал

Аливаа улсын хөгжил боловсролын чанараас хамаарна. Боловсролын чанарын нэг суурь үзүүлэлт нь сургалтын хөтөлбөр юм. Монгол Улсад албан боловсролын тогтолцоо үүссэнээс эдүгээ хүртэл арав гаруй удаа СӨБ болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг өөрчлөн шинэчилжээ. Тэдгээрийг боловсруулахад баримталсан үзэл баримтлалууд цөөхөн ажээ. Үүнд: 2002 онд үндэсний хэв шинжтэй боловсролын стандарт ба киррикулимийг шинэчлэх үзэл баримтлал, 2013 онд боловсролын цөм хөтөлбөр боловсруулахад бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал хэмээх баримт бичигт тулгуурлан, сургалтын хөтөлбөр, стандартуудаа боловсруулжээ (БСҮХ, 2019).

Манай улсын боловсролын салбарт тулгарч буй асуудал бол сургалтын бодлого,

хөтөлбөр нь ойр ойрхон солигддог явдал юм. Энэ нь хөтөлбөр хэдий сайн ч үр дүнг нь хүртэхгүйгээс гадна өмнөх хөтөлбөрийн хэрэгжилт дээрээ тулгуурлан, судалгаанд суурилсан шинэчлэл хийх боломж олгодоггүй. Иймээс 2018 оны 8-р сарын 30-нд БСШУСЯ-ны Сайдын А/549 дүгээр тушаалаар “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал” батлагдсан нь сургалтын хөтөлбөрийг 10 жилийн мөчлөгтэй шинэчлэх үйл явцыг эрх зүйн хүрээнд тодорхой болгожээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 4-р сарын 24-ний А/176 тоот тогтоолоор батлагдсан “СӨБ болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (Хойшид шинэ үзэл баримтлал гэх) хэмээх баримт бичиг гарсан бөгөөд энэ нь анх удаа Засгийн газрын тогтоолоор батлагдаж байгаагаараа онцлог юм. (МУЗГ, 2024). Энэхүү сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг 2024-2036 онд мөрдөж хэрэгжүүлэх юм. Шинэ үзэл баримтлалын агуулгыг судалж, боловсролын харилцааны оролцогч талуудад танилцуулах нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн эхний алхам юм. Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг өргөн хүрээнд задлан шинжлэх нь тухайн сургалтын хөтөлбөр юуг өгүүлж байгаа, түүнд юу багтаж байгаа, хэн оролцож, хэнд үйлчлэх талаар тодруулж өгдөг. (Alan C. Ornstein & Francis P. Hunkins, 2018).

Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал нь тухайн сургалтын хөтөлбөрийн үндсэн зорилго, агуулга, бүтэц, онцлогийг тодорхойлдог. Зарим талаараа сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг тодорхойлох нь хамгийн хэцүү ажил юм (Allan A. Glatthorn; et al., 2019).

Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа өмнөх хөтөлбөрийн хэрэгжилт, бэрхшээл, боловсролын урт хугацааны зорилго, зорилт, хүүхэд судлалын шинэ чиг хандлага, боловсролын болон суралцахуйн онолын хөгжлийн чиг хандлага, судлагдахуун судлалын чиг хандлага, сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийн чиг хандлага зэргийг үндэслэл болгодог (Оюунцэцэг, 2023).

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаагаар шинэ үзэл баримтлалд T-LAB10 программ ашиглан, агуулгын шинжилгээ хийлээ. Агуулгын шинжилгээг шинэ үзэл баримтлалын бүтэц, үгийн тоо болон давтамж, кластерууд, хамгийн их давтагдсан үгийн бусад үгтэй холбогдсон байдал, сонирхож буй үгсийн холбоо хамаарал зэрэг үзүүлэлтээр хийлээ.

Судалгааны үр дүн

СӨБ болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл баримтлалд агуулгын шинжилгээг а) бүтэц, б) үгийн давтамж в) үгсийн холбоо хамаарал, г) кластер шинжилгээ, д) онцлог гэсэн үндсэн үзүүлэлтээр хийлээ. Эдгээр үзүүлэлт тус бүрээр хийсэн шинжилгээний үр товч тайлбарлая.

а) Бүтэц: Шинэ үзэл баримтлал нь 6 үндсэн бүлэг, 16 зүйл бүхий 26 хуудас баримт бичиг юм. Бүтцийг нь Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Үзэл баримтлалын бүтэц

№	Бүлэг	
1	Нийтлэг үндэслэл	1.1 Хууль, эрхзүйн үндэслэл, шаардлага 1.2 Практик шаардлага
2	Үзэл баримтлалын зорилго, хамрах хүрээ	2.1 Үзэл баримтлалын зорилго 2.2 Монгол суралцагчийн эзэмших чадамж 2.3 Хамрах хүрээ
3	Сургалтын хөтөлбөр, түүний бүтэц, боловсруулахад тавигдах шаардлага	3.1 Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад баримтлах зарчим 3.2 Сургалтын болон судлагдахууны хөтөлбөрийн нийтлэг бүтэц, боловсруулахад тавигдах шаардлага 3.3 Сургалтын хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэхэд тэгш хамруулах зарчим
4	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга зам	4.1 Сургалтын төлөвлөгөө, хугацаа 4.2 Суралцахуйн онол, арга, хэлбэр 4.3 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд цахим технологийг ашиглахад баримтлах чиглэл 4.4 Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, дэд бүтэц 4.5 Суралцагчийн үнэлгээ 4.6 Сургалтаас гадуурх үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талууд
5	Сургалтын хөтөлбөрийн тогтвортой байдал, хэрэгжилтийн хяналт, үнэлгээ	5.1 Сургалтын хөтөлбөрийн тогтвортой байдал
6	Нэр томъёоны тайлал	6.1 116 Нэр томъёог тайлбарласан

Бүлэг бүрийн агуулгыг товч тайлбарлавал: Нэгдүгээр бүлэг болох нийтлэг үндэслэлд уг сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хийх хууль эрх зүйн үндэслэл, шаардлагыг боловсролын салбарын НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” гэх мэт олон улсын болон Боловсролын ерөнхий хууль, урт хугацааны хөгжлийн бодлого-“Алсын хараа-2050”, 2021-2030 онд хэрэгжүүлэх Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө зэрэг үндэсний баримт бичгүүдэд туссан хэрэгцээ, шаардлагын хүрээнд авч үзжээ. Мөн практик шаардлагыг боловсролын олон улсын PISA үнэлгээний үр дүнд хийсэн шинжилгээ, үндэсний хэмжээнд боловсролын салбарын томоохон судалгаануудын үр дүнд тулгуурлан боловсруулсан байна. Хоёрдугаар бүлэгт шинэ үзэл баримтлалын зорилгыг “Суралцагчийн эзэмших чадамжийг тодорхойлж, эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, судлагдахууны хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, арга зүй, үнэлгээний нийцтэй байдлыг харгалзан боловсруулах үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ. Мөн Монгол суралцагчдын эзэмших суурь болон ерөнхий чадварыг тодорхойлжээ. Суурь чадварт судлагдахууныг ерөнхий чадварт бүх судлагдахуунаар дэмжиж хөгжүүлэх чадваруудыг багтаажээ. Ерөнхий чадварт шинээр нэмэгдэж орсон нь нийгэм-сэтгэл хөдлөлийн чадамж байна. Эцэст нь уг үзэл баримтлалын хамрах хүрээг тодорхойлжээ. Гуравдугаар бүлэгт сургалтын хөтөлбөрийг боловсруулахад баримтлах зарчмыг сургалтын хөтөлбөр гэж ямар бичиг баримт болох, ямар

түвшинтэй байх, мөн чадамжид суурилсан байхыг заажээ. Түвшин бүр сургалтын хөтөлбөртэй, сургалтын хөтөлбөр нь судлагдахууны хөтөлбөрүүдтэй байхыг тусгахаас гадна тэдгээрийн нийтлэг бүтэц, боловсруулахад тавигдах шаардлагыг тусгажээ. Мөн сургалтын хөтөлбөр боловсруулах болон хэрэгжүүлэхэд тэгш хамруулах зарчим, аргазүйг суралцагч бүрд тэгш боломж олгож, ганцаарчилсан, нэмэлт, дэмжих, жишиг хөтөлбөртэй байж болохоос гадна хос хэлний сургалтад хэл агуулгыг интеграцчилан заах арга зүйг хэрэгжүүлэхээр тусгажээ. Дөрөвдүгээр бүлэгт сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга замыг тодорхойлохдоо сургалтын төлөвлөгөө, хугацааг түвшин бүрт хэд байхыг зааж, суралцахуйн онол арга зүйг СӨБ-ын сургалтад тоглоомд болон зохиолд суурилсан арга зүй; бага ангид тоглоомын, орчинд суурилсан, шинжлэн судлах арга зүй; дунд ангид асуудалд суурилсан болон шинжлэн судлах арга зүй, орчинд суурилсан болон хамтран суралцах арга зүй; ахлах ангид асуудал болон төсөлд суурилсан арга зүй, шинжлэн судлах болон оролцоонд суурилсан арга зүйг голлоно гэжээ. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд цахим технологийг ашиглахад баримтлах чиглэлд сургалтын болон үнэлгээний үндэсний нэгдсэн платформтой байхаар тусгажээ. Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, суралцагч төвтэй, сургалтын таатай орчныг бүрдүүлэх чиглэлийг тодорхойлж, суралцахуйн үнэлгээг оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд суралцагчийн эзэмшсэн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт дахь мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлох, тэдэнд дэмжлэг үзүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэхийг тусгажээ. Төгсгөлд нь сургалтаас гадуурх үйл ажиллагаа болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талуудыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон төр, төрийн бус байгууллага, олон нийтийн түншлэл хэмээн тодорхойлжээ. Тавдугаар бүлэгт сургалтын хөтөлбөрийн тогтвортой байдал гэсэн гарчигтай боловч сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг 2-3 жил тутамд, судлагдахуун бүрийн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг шалгуур үзүүлэлт болгон суурь түвшин, 2025, 2030, 2035 онд хүрэх түвшинг тусгаж, үнэлгээг ямар байгууллага ямар үнэлгээгээр зохион байгуулж үнэлэхийг тусгажээ. Зургаадугаар бүлэгт уг үзэл баримтлал дахь 116 нэр томъёог хэрхэн ойлгогдож хэрэглэснийг тайлбарлан оруулжээ.

б) Үгийн давтамж: Шинэ үзэл баримтлал нь 6563 үг бүхий 26 хуудас баримт бичиг бөгөөд үгийн давтамжийг хоёр аргаар тогтоолоо. Үүнд: 1. Хамгийн олон давтамжтай үгсийн үүлэн зураглал (Зураг 1), 2. амгийн их давтамжтай эхний 30 үгийн хүснэгт (Хүснэгт 2) -ийг гаргалаа.

Зураг 1. Хамгийн олон давтамжтай үгсийн үүлэн зураглал



Хүснэгт 2. Хамгийн их давтамжтай үгсийн жагсаалт


№	Үгс	дав-тамж	№	Үгс	дав-тамж	№	Үгс	дав-тамж
1	СУРГАЛТЫН	81	11	БОЛОВСРОЛЫН	30	21	ҮЗЭЛ	21
2	БОЛОН	65	12	ХӨТӨЛБӨРИЙН	30	22	ҮНЭЛГЭЭ	21
3	ҮЙЛ	50	13	ХАНДЛАГА	24	23	ЭЗЭМШИХ	20
4	НЬ	45	14	БОЛОВСРОЛ	24	24	СУРГУУЛИЙН	20
5	МЭДЛЭГ	41	15	ОЛОН	23	25	СУРАЛЦАХ	20
6	СУРАЛЦАГЧИЙН	40	16	СУРАЛЦАХУЙН	23	26	LEARNING	20
7	ҮР	39	17	СУУРЬ	23	27	МОНГОЛ	19
8	ЧАДВАР	39	18	ХӨТӨЛБӨР	23	28	УЛСЫН	19
9	АРГА	38	19	ЯВЦ	23	29	НИЙГМИЙН	18
10	БАЙНА	32	20	СУРАЛЦАГЧ	22	30	ЗҮЙ	18

Үгийн давтамжийг тогтоосон дээрх хоёр аргын үр дүнд тулгуурлан, дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:


- Үүлэн зураглал дээр “суралцахуй”, “үйл”, “цахим”, “чадамж” гэдэг үг томоор бичигдсэн нь эдгээр үгс энэхүү баримт бичигт голлох үүрэгтэй оролцжээ. “Суралцахуй” нь “багшлахуй” гэдэг үгээс томоор бичигдсэн нь суралцагчийн суралцах үйлд багшийн үйлээс илүү ач холбогдол өгснийг илтгэнэ. Мөн “суралцагч” гэсэн үг дээрх хүснэгт дээр 62 байгааг лавшруулан, шинэ үзэл баримтлалыг бүхэлд нь үг тоолох хэрэглүүрийг ашиглан тоолоход 97 удаа гарч буй нь суралцагчдыг голлон анхаарсныг батлан харуулж байна.
- Хүснэгт 2 дээр “мэдлэг”-41, “чадвар”-39, “хандлага”-24 байгаа нь уламжлалт мэдлэгт суурилсан суралцахуйн хандлага хадгалагдсаар байгааг харуулж байна. Мөн эхний 30 үг дотор “чадамж” гэдэг үг багтаагүй байгаа нь мэдлэг, чадвар, хандлагыг хамтад нь авч үзээгүйг илтгэж байна. Түүнчлэн “үнэт зүйл” гэдэг үг 4 удаа орсон нь чадамж дотор үнэт зүйлийг багтаагаагүйг харуулж байна.

Зураг 3-д дүрслэгдсэн “Суралцагч” хэмээх ухагдахуун нь “бүрийн”, “боломжийг” “бүрдүүлэх” зэрэг үгтэй хамгийн их холбогдсон байна. Уг баримт бичигт “суралцагч бүрийг” хөгжүүлэх, дэмжих санааг тусгасан нь сайшаалтай.

Зураг 4. “Үйл” төвт ухагдахууны тогтолцоо




Зураг 5. “Цахим” төвт ухагдахууны тогтолцоо



Зураг 4-д “Үйл” гэдэг үг нь “явц”, “суралцах”, “ажиллагаа” гэсэн үгтэй хамгийн их холбогдсон байна. Энэ нь үйлийн явцад мэдлэгийг зохиомжлон бүтээдэг хэмээх конструктивизмын гол үзэл санааг баталж байна. Зураг 5-д “цахим” гэдэг үг “компьютерын”, “технологийн”, “суралцахуйн” зэрэг үгтэй хамгийн их холбогдсон байна. Энэ нь цахим технологи хэрэглэхийг тусгасныг харуулж байна. Лавшруулан “цахим технологи” гэсэн үгийг үг тоолох хэрэглүүрээр тоолоход 8 удаа ашигласан байна.


Зураг 6. “Мэдлэг” ба “чадвар” гэсэн үгийн холбоо хамаарлын зураглал



Зураг 6-гаас дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- “Мэдлэг, чадвар, хандлага” гэсэн үгс шууд холбогдсон байна. Энэ нь уг үзэл баримтлалд сургалтын хөтөлбөрийг чадамжид суурилсан байхаар тусгасныг баглах ажээ. Мөн хамгийн тод холбох шугам нь эдгээр үгийн хооронд зурагдсан байна.
- “Мэдлэг” ба “чадвар” нь “төлөвшил” гэдэг үгтэй шууд бусаар холбогдсон байгаа нь анхаарал татаж байна. Учир нь үзэл баримтлалын 6-р бүлэгт чадамж гэдэг ухагдахууныг тодорхойлохдоо “Тодорхой нөхцөл байдалд нийцэхүйц мэдлэг, чадвар, төлөвшлийн цогцоор илрэх гүйцэтгэл” гэсэнд нийцэхгүй байна.

Зураг 7. “Монгол” ба “суралцагч” гэсэн үгийн холбоог харуулсан зураглал




Зураг 7-гоос харахад уг сонирхсон хоёр үг болох “монгол” ба “суралцагч” гэсэн үгс хоорондоо шууд холбогдоогүй байна. Харин “монгол” хэмээх үг нь эдийн, улсын, засгийн гэсэн үгстэй шууд холбогдсон байгаа нь “монгол суралцагч” гэсэн мөн чанар бүрэн тусгагдсан нь эргэлзээтэйг илтгэнэ.

г) Кластер шинжилгээ:

Агуулгыг хэдэн кластерт хуваагдаж байгааг сонирхвол суралцагч, сургалт төвтэй хөх өнгийн кластер, мэдлэг, чадвар, хандлага төвтэй улаан өнгийн кластер, үйл гэсэн үгээр төвөө хийсэн бор өнгийн кластер, суралцахуй төвт улбар шар кластер гэх мэт 10 гаруй кластер тодорхой харагдаж байна.

Зураг 8. Кластер шинжилгээ



Кластерийн зураглалаас дараах дүгнэлт гарч байна. Үүнд:

- Өмнөх шинжилгээнүүд дээр илэрсэн суралцагч болон суралцахуй үзэл баримтлалын агуулгын гол цөм болохыг дахин харуулж байна.
- Энэ удаагийн шинэ үзэл браимтлал нь СӨБ болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг хамтад нь хамруулсан гэсэн санаа нь ногоон кластер дээр харагдаж байгаа нь сайшаалтай.
- Мөн үйл явц нь үр дүнд чиглэсэн, үнэлгээтэй холбогдсон нь бор өнгийн кластерт дүрслэгджээ.
- Улаан өнгийн кластерт төлөвшил гэдэг үг хамрагдаагүй нь зураг-6 дээрх дүрслэлтэй адил байна.

д) Онцлог:

Энэхүү агуулгын шинжилгээнд тулгуурлан шинэ үзэл баримтлалын онцлогийг тодорхойлбол:

- Суралцагч төвтэй
- Суралцахуйг голлосон

- Үйлийн явцад суралцах
- Чадамжид суурилсан, гэвч чадамж дотроо мэдлэг чадвар нь шууд холбогдсон боловч төлөвшил нь шууд холбогдоогүй
- Мэдлэг>чадвар>хандлагын харьцаа уламжлалт хэв маягтай
- Цахим технологийг сургалтад хэрэглэхийг тусгасан байна.

Дүгнэлт

СӨБ болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд ТЛАВ-10 программын тусламжтайгаар агуулгын шинжилгээг а) бүтэц, б) үгийн давтамж, в) үгсийн холбоо хамаарал, г) кластер шинжилгээ, д) онцлог гэсэн чиглэлээр хийлээ. Энэ удаагийн шинэ үзэл баримтлал нь суралцагч болон суралцахуй төвтэй, хөндлөн болон босоо холбоо хамаарлыг сайтар баримталсан, цахим технологийг тусгасан зэрэг сайн талууд байна. Мөн чадамжид суурилсан гэсэн боловч чадамжийн тодорхойлолтод мэдлэг, чадвар, төлөвшлийг хамтад нь авч үзсэн хэрнээ агуулгын шинжилгээгээр мэдлэг ба чадвартай “төлөвшил” нь шууд холбогдохгүй байна. Мөн суралцагч төвтэй боловч монгол суралцагчийн онцлогийг тусгасан нь тодорхой харагдахгүй байна.

Уг үзэл баримтлалыг бүх талаас нь задлан шинжилж хэлэлцэх нь түүнийг сургалтын хөтөлбөр болон сурах бичиг, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх эхний алхам болохыг онцлон тэмдэглэж байна.

Ном зүй

1. Alan C. Ornstein & Francis P. Hunkins. (2018). Curriculum: Foundations, Principles, and Issues. England: Pearson Education Limited.
2. Allan A. Glatthorn; Bruce M. Whitehead; Floyd Boschee; Bonni F. Boschee.,. (2019). Curriculum Leadership, V edition. USA: SAGE.
3. БСҮХ. (2019). Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. Улаанбаатар: Гоо Дизайн ХХК.
4. МУЗГ. (2024 оны 04 24). Legalinfo.mn. Legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353213781-ээс> Гаргасан
5. Оюунцэцэг, Н. (2023). 21 дүгээр зууны боловсрол Насан туршийн суралцахуй. Улаанбаатар: Соёмбо принтинг.

CONTENT ANALYSIS CONDUCTED ON THE CONCEPTUAL FRAMEWORK OF THE CURRICULUM FOR PRESCHOOL AND GENERAL EDUCATION SCHOOL

^aAmartuvshin D., ^bDelgermurun O.

^aPhD., associate professor, Teachers School, MNUE;

^bMaster, Lecturer, Teachers School, MNUE

Corresponding author: delgermurun@msue.edu.mn 

Abstract

This study aims to conduct a content analysis of the “Conceptual Framework of the Curriculum for Preschool and General education school,” approved by the Government of Mongolia under order A/176 on April 24, 2024. The analysis utilizes the TLAB-10 program to investigate the structure, objectives, specific characteristics, and content of the conceptual framework. The content analysis is performed based on various indicators, including the structure of the new conceptual framework, word count and frequency, clusters, relationships of frequently repeated words with other terms, and correlations of relevant keywords. From the analysis, the conceptual framework is student-centered and based on competence. And it considered digital technology and social-emotional competence. There is a gap for concept “competence”. In the content analysis, the concept “competence” did not involve the concept “formation”.

Keywords

Word Associations, learner, knowledge, skills, attitude, cluster analysis
